



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/111

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын ширээ, сандлын шинэчлэл ажлын ХОАОНӨГ/202001119 гэрээний гүйцэтгэгч “Улаанбүрд” ХХК-ийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Даваадорж – Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Энхмандал – Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
нягтлан бодогч

Д.Нямдорж – Боловсрол, соёл урлагийн газрын төсөв, хөрөнгө  
оруулалт хариуцсан мэргэжилтэн


Б.Түмэнжаргал – Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн

дарга: Ж.Батбаяр – Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол, шинжлэх  
ухааны асуудал мэргэжилтэн

2. Ховд аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын ширээ, сандлын шинэчлэл ажлыг захиалагчаас баталсан техникийн тодорхойлолтын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/111 Ch  
02 0773